



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

206 /206/ 2021.12.22

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1978 он.

БХЯ-ны сайдын “Хугацаат цэргийн алба хаагчдын ахуй амьдралд тавих халамж анхаарлыг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаал гарчээ.

БАЙЛДААНЫ ТУГ ГАРДУУЛАН ӨГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО



Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалууд болох Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газарт Байлдааны тугийг нь гардуулан өгөх ёслолын ажиллагаа өнөөдөр боллоо.

Тус ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүн болон командлагуудын харьяа ангийн захирагч нар оролцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний Тусгай хүчний командлагч бригадын генерал Б.Баатар, Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, бригадын генерал Д.Баасандамба, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан нарт Байлдааны тугийг гардуулан, баяр хүргэж үг хэллээ. Тэрээр “Зэвсэгт хүчинд Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрыг байгуулагдаж, бие даан үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн юм. Өнөөдөр Та бүхэн сүлд хийморийн бэлгэдэл болсон төрлийн цэргийн Байлдааны тугийг Монгол Улсын Цэргийн дүрмийн дагуу ёслол төгөлдөр гардан авлаа. БХЯ-наас

шинээр байгуулагдсан төрлийн цэргийг хөгжүүлэн бэхжүүлэх, бие даасан үйл ажиллагаа явуулахад шаардлагатай төсөв, санхүү, орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх, зэвсэглэл, техник, материал хэрэгслээр үе шаттайгаар хангах асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэж, дэмжлэг үзүүлж ажиллах болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт болон байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах ажилд тэргүүлэн оролцох, улс орны болон батлан хамгаалах салбарын кибер аюулгүй байдлыг хангах, тусгай томилгоот үүрэг гүйцэтгэх чадавхыг бүрдүүлэх, түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд дахь оролцоог нэмэгдүүлэх томоохон үүрэг, хариуцлага Та биднийг хүлээж байна” гэдгийг тодотгосон юм.

Мөн энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг хэлсэн үгэндээ “2020 онд хууль эрх зүйн хүрээнд Зэвсэгт хүчний Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрыг шинээр байгуулсны зэрэгцээ тэдгээрийн бие даан үүрэг гүйцэтгэх боломжийг нь бүрдүүлэх чиглэлээр үе шаттай ажлуудыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага дэс

дараатай хэрэгжүүлсээр байгаа юм. ЗХЖШ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурлаас “Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газрын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тодорхой үр дүнтэй явагдаж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг бүрэн хэрэгжүүлсэн” хэмээн үнэлсэн нь эдгээр төрлийн цэргийн командлал, удирдах газар нь харьцангуй богино хугацаанд бие даан төлөвших эхлэлийг зөв тавьж буйг илтгэж байна. Энэ өдөр Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Байлдааны тугийг гардуулж байгаа нь дээрх хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангаж, эдгээр байгууллагын бие даан үүрэг гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүлж, удирдлага, бие бүрэлдэхүүний ажиллах урам зориг, итгэл үнэмшлийг бадрааж байна. Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангийн Байлдааны туг нь бие бүрэлдэхүүний сүслэн дээдлэх ариун шүтээн, оройн сүлд, золбоо хийморийн бэлгэдэл юм. Тиймээс энэхүү Байлдааны туг нь аливаа бахдам үйлс, бахархам түүх, амжилт, ололт, алдар гавьяа бүхний тэргүүн манлайд Монгол төрийн алтан соёмбот далбааны нэгэн адил өндөрт мандаж явах учиртай бөгөөд Та бүхэн ч өөрсдийн хичээл зүтгэлээрээ тийнхүү мандуулж явах үүрэгтэй бас эрхтэй” хэмээн онцлолоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,171.0	3,242.0
CNY	444.30	447.70
RUB	37.60	39.10
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ

2021.12.22 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ЭДӨР

Үс засуулбал:
Эд малын гарлагатай
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.40-17.02
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Сансар
Суудал:
Ус

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адеуус муулах, лус тахих, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Өвлийн туйл болох улирал (0 цаг 45 мин)-д эхэлнэ. Хүйтний ес эхэлнэ. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЕРЭГ сайн

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН
2.264.962 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН
2,161.328 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
862.179 26,5%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6914 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
197

ЭДГЭРСЭН
6589

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 276,611,809

Эдгэрсэн
Нийт: 248,139,780

Нас барсан
Нийт: 5,385,745

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР БҮХИЙ Л САЛБАРЫН ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛСААР ИРСЭН

БХЯ үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойд зориулан “Зүүн хойд Азийн аюулгүй байдал: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.САЙХАНБАЯРЫН хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна

Эрхэм хүндэт олон улсын эрдэмтэн, судлаачид аа,

Эрхэм зочид оо, Эрхэмсэг хатагтай, ноёд оо,

Эрхэм генерал, офицерууд аа.

Та бүхний энэ өдрийн амрыг эрэн мэндчилье.

Монгол Улс ХХ зууны эхэнд буюу 1911 онд Богд хаант Монгол Улсаа байгуулан, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан түүхтэй ард түмэн.

Улмаар тухайн үед Богд хааны зарлигаар анхны таван яамыг байгуулсан бөгөөд түүний нэг нь “Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам” байсан нь өнөөгийн Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага болох Батлан хамгаалах яам байж, өдгөө 110 жилийн ойтойгоо золгож байна.

Юуны өмнө энэхүү түүхт ойн баярын мэндийг Батлан хамгаалахын сайдын болон салбарынхаа нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс Та бүхэнд өргөн дэвшүүлье.

Аливаа улс орны төр, засгийн болон батлан хамгаалахын удирдлага, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын өөрчлөлтийг нэн тэргүүнд мэдэрч, түүний нөлөөллийг үнэлсний үндсэн дээр цаашдын улс орны болон бүс нутгийн цэрэг-улс төрийн байдал, батлан хамгаалах үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдолд ихээхэн анхаарч, Зэвсэгт хүчин, цэрэг, армия хөгжүүлэх бодлого, зорилтоо тодорхойлж, тавигдсан ямар ч үүргийг биелүүлэхэд бэлтгэх боллоо.

Монгол Улс, монгол цэргийн хувьд 1911 онд харийн ноёрхлыг түлхэн унагаж Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, улмаар 1921 онд Ардын хувьсгалыг эхлүүлэн улс орноо тэгшитгэж, 1939 онд харийн түрэмгийлэгчдийн эсрэг эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоо хамгаалан Халхын голд тулалдаж, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцон зүүн хойд Хятадыг чөлөөлөцөж, улсын баруун хилд болсон зэвсэгт тулгаралтад эх орныхоо тусгаар тогтнолыг бататган байлдаж, Ялалтын уухайг цуурайтуулж явсан нь өнөөгийн ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ байдлын орчны өөрчлөлтөд томоохон хувь нэмэр оруулж байсан гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Уг тэмцэл, дайн,

байлдаан, зэвсэгт тулгаралтад тухайн үеийн “Цэргийн явдлын яам” нь зөв бодлого, стратегийг тодорхойлон явуулж, бүхий л талын хангалт, үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж чадсан нь улс орноо төдийгүй бусад улсуудыг ч дайны хар сүүдрээс ангижруулах баатарлаг үйлс, их түүхийг бүтээлцсэн байдаг.

Мөн өнгөрсөн хугацаанд тус яам нь улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ улс төр, гадаад харилцаа, нийгэм, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, соёл урлаг, бүтээн байгуулалтын зэрэг бүхий л салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Улмаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгүүдэд тусгагдсан “... улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах” зорилтыг хэрэгжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг тогтворжуулах, энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцох оролцоогоо нэмэгдүүлэх зэрэг туйлын чухал зорилтуудыг хэрэгжүүлсээр байгаа юм.

Тийм ч учраас бүс



нутагт аюулгүй, тогтвортой байдлыг бий болгох, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл хэрэгт ач холбогдол бүхий олон улсын эрдэм шинжилгээний хурлыг “Зүүн хойд азийн аюулгүй байдал: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдвээр Батлан хамгаалах яамныхаа ойг тохиолдуулан зохион байгуулж байгаагаараа энэ удаагийн хурал онцлог болж байгааг тэмдэглэн хэлье.

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, энх тайван, амар амгалан амьдрал үгүйлэгдэж байгаа улс орон, ард түмэнд туслахыг байнга эрмэлзэж, олон улсын болон бүс нутгийн аюулгүй

байдлыг бэхжүүлэх талаар гаргасан аливаа санал, санаачилгуудыг талархан дэмжиж, үйл хэрэгт нь идэвхтэй оролцоор байна.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлаар бус нутгийн улс орнуудын аюулгүй байдлын талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд эрдэмтэн, судлаачид Та бүгдийн тавьсан илтгэл, хэлэлцүүлэг, санал, дүгнэлтүүд ихээхэн дэмжлэг үзүүлнэ гэдэгт Сайд миний бие итгэл дүүрэн байна.

Энэхүү хуралд уригдан оролцож, бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлаар өөрийн илтгэлээ хэлэлцүүлж,

санал бодлоо хуваалцаж буй гадаад улсуудын эрдэмтэн, судлаачид болон уг хурлыг амжилттай зохион байгуулахад хамтран ажиллаж буй улс орнуудын Цэргийн атташе нартаа чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Ингээд “Зүүн хойд азийн аюулгүй байдал: Итгэлцлийг бэхжүүлэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсэж, Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, бүтээл туурвилын арвин их амжилтыг хүсэн ерөөе.

Номын цагаан буян үргэлжид дэлгэрэх болтугай.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АЖЛАА ТАЙЛАГНАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд төр болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нэгдэн мод тарьцгааж буй. Тэгвэл “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад хийгдэж байгаа ажилтай танилцаж, дүн шинжилгээ хийх зорилготой хурал Батлан хамгаалах яаманд боллоо. Тус хуралд БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ, ШШГЕГ, ТТХГ-ын төлөөллүүд оролцов.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч хурандаа Ж.Болдбаатар хурлыг нээж, дарааллыг танилцуулснаар эхэнд нь ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал мэдээлэл өглөө.

Тэрбээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбарт 2021-2030 он хүртэл хэрэгжүүлэх төсөл

арга хэмжээний талаар танилцуулав. Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хурлуудаар хэлэлцэгдсэнээр нийтдээ 6 чиглэлээр дээрх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгааг бригадын генерал Ч.Цогтжаргал онцолсон.

Энэ хүрээнд Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуу элсний нүүдлээс хамгаалах ногоон зурвас Агрофарк, Зэвсэгт хүчний хэмжээнд нийтдээ 9 байрлалд мод үржүүлгийн газар байгуулах юм. Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад ногоон хотхон, Агрофарк байгуулахаар төлөвлөсөн гэдгийг тодотголоо. Тэрчлэн хот хоорондын автозамын дагуу орон нутгийн байгууллагуудтай хамтарч ногоон зурвас байгуулах, заган ойг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлж оролцох, Батлан хамгаалах салбарын ажилтан алба хаагчдын амьдарч буй орчиндоо мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд татан

оролцуулж, дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллана гэв. Үргэлжлүүлэн бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын төлөөллүүд “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд хийгдэж байгаа, цаашид төлөвлөсөн ажил, арга хэмжээний талаар танилцуулав.

Мөн энэ үеэр байгууллагуудаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэртэй танилцаж, түүнийг хэрэгжүүлэх тооцоо судалгаа, төлөвлөлтийн баримт бичгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн юм.

Төгсгөлд нь хурандаа Ж.Болдбаатар хуралд оролцсон бүрэлдэхүүнд судалгаа тооцоог нарийвчлан гаргаж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд өрнүүлж буй ажлуудаа эрчимжүүлэх, 2021-2030 он хүртэлх үечлэлд нийцүүлж нарийн төлөвлөн хэрэгжүүлэх зэрэг зөвлөмж өглөө.

